

АЙМГИЙН ИТХ-ЫН ТӨЛӨӨЛӨГЧ, ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНААС
2018 ОНЫ СҮҮЛИЙН ХАГАС ЖИЛД БАТАЛСАН ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ

2018.12.03

№	Тогтоолын дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Заалтын дугаар	Заалтын агуулга	Хариуцан хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжилт	Хувь	Хувь
1	12	Аймгийн хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөр батлах тухай 2018,01,04	3	Хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөр болон төлөвлөгөөг орон нутагтаа хэрэгжүүлж ажиллахыг сумдын Засаг дарга нар, тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргад тус тус даалгасугай.	Аймгийн Засаг дарга О.Бат-Эрдэнэ, сумдын Засаг дарга нар	“Хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г 4 зорилтын хүрээнд 15 зүйл заалт бүхий төлөвлөгөөг газрын даргаар тус тус батлуулан хэрэгжүүлэв. Төлөвлөгөөний хэрэгжилт 12 сарын байдлаар 90 хувийн хэрэгжилттэй байна. Байгаль орчин аялал жуулчлалын газраас “Орчны бохирдлыг бууруулах, хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөр, төлөвлөгөө, энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам”-ын хэрэгжилтийг хангах талаар 03-р сард сумдын мэргэжилтэн, байгаль хамгаалагч нарын нэгдсэн сургалтад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. Агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр агаарын бохирдлын эх үүсвэрийн тооллогыг зохион байгуулж, тооллогын дүнг нэгтгэж, тайланг 12-р сард багтаан боловсруулна. Мөн Сайнцагаан сумын уур болон усан халаалтын зууханд холбох боломжтой нам даралтын зуухны судалгааг гаргасан. 2018 онд “Монголын байгаль орчин, аюулгүй байдлын төв” ТББ, БОАЖГазартай хамтран Сайнцагаан, Дэлгэрцогт сумдын нутагт хөрсөнд асгарсан техникийн тостой газар болон үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуй нэгжүүд болон айл өрхүүдийн ойролцоох хөрсний бохирдол бүхий 32 цэгт хүнд металлын агуулгыг хэмжих замаар бохирдлын түвшин, тархалтыг хэмжүүлж, уг судалгааны тайланг гарган, зөвлөмжийн дагуу сумдад чиглэл өгч ажиллалаа.	100	70

						“Байгаль ээлтэй амьдрах үйлдлүүд болон хог хаягдлын хуулийн шинэчилсэн найруулгын талаар”, “Мод тарих, арчлах талаар” сургалтуудыг Сайнцагаан, Гурвансайхан сумын цэцэрлэг, сургуулийн багш, ажилчид, ахлах ангийн болон эко клуб сурагч, багийн иргэд, ААНБайгууллагуудад зохион байгуулж, гадна орчинд зөвлөгөө өгч ажиллалаа. Сургалтанд нийт 450 багш сурагчид, албан хаагчид хамрагдаж 600 гаруй брошур, гарын авлага, зөвлөмж тараасан.		
2	34	Өмчлүүлэх газрын зориулалт байршил хэмжээг батлах тухай 2018.03.15	2	Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль болон мөрдөх журманд орсон нэмэлт өөрчлөлт, энэ тогтоолыг хэрэгжүүлэх, газар өмчлөлийн ажлыг эрчимжүүлж ажиллахыг аймаг, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Аймаг, сумдын Засаг дарга нар	2018 онд аймгийн хэмжээнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар нэг удаа үнэ төлбөргүй газар өмчилж авах хүсэлт өргөдөл 3504 хүлээн авч үүний 78 хувь буюу 2741 иргэнд 207,9 га газар өмчлүүлсэн байна. Үүнд: - Одоо эзэмшиж байгаа хашааны газраа өмчлөх 50 иргэнд 5,76 га, - Шинээр газар өмчлөх 1586 иргэнд 124,79 га, Улсын чанартай автозам дагуу 1105 иргэнд 77,35 га газрыг тус тус өмчлүүлэх аймаг сумын Засаг даргын шийдвэр гаргуулсан байна. 2018 онд 2741 иргэнд, 2017 онд 2737 иргэнд газар өмчлүүлсэн байна.	100	70
3	64	Нэрэмжит болгох тухай 2018.05.24	2	И.Рэнчинхандын ном, хэвлэл мэдээллийн салбарын хөгжилд оруулсан гавъяат үйлсийг олон нийтэд сурталчлан алдаршуулах, хамтын ажиллагаагаа хөгжүүлэхэд идэвх санаачлагатай ажиллахыг Сайхан-овоо сумын Засаг дарга, Соёлын төвийн эрхлэгч нарт үүрэг болгосугай.	Сайхан-овоо сумын Засаг дарга Б.Түвшинбаатар, Соёлын төвийн эрхлэгч Н.Баярмаа	2018 оны 09 дүгээр сарын 14-нд тус сумын Соёлын төвийн номын сан нь МУСГЗ сэтгүүлч И.Рэнчинхандын нэрэмжит номын сан болж нээлтээ хийлээ. Нээлтийн үеэр СГЗ И.Рэнчинханд “Дэлхийн Монголчуудын түүх” 9 боть номыг хандивлалаа.	100	100

4	70	Өлзийт сумын ЕБС-ийг нэрэмжит болгох тухай 2018,06,27	2	Д.Нямаагийн бүтээл туурвилыг судлан залгамж хойч үедээ түгээн дэлгэрүүлж, гавъяат үйлсийг олон нийтэд сурталчлан алдаршуулахад идэвх санаачлагатай ажиллахыг тус сумын Засаг дарга, ЕБС-ийн захирал нарт үүрэг болгосугай.	Өлзийт сумын Засаг дарга А.Эрдэнэбат, ЕБС-ийн захирал М.Болормаа	Аймгийн ИТХ-ын 2018 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 10 дугаар тогтоолоор ЕБС-ийг Д.Нямаагийн нэрэмжит болгосон. Төрийн шагналт, СГЗ яруу найрагч Долгорын Нямаагийн нэрэмжит болгох ёслол хүндэтгэлийн арга хэмжээ 2018 оны 9 дүгээр сарын 3-нд зохион байгуулагдаж тус үйл ажиллагаанд Д.Нямаа агсны гэр бүл, үр хүүхдүүд болон зохиолчдын төлөөлөл болон 100 гаруй иргэд оролцлоо.   2. Д.Нямаа агсны 79 насны ойг тохиолдуулан найрагчийн уран бүтээлийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор сурагчдын дунд “Уран үгсийн чуулган” яруу найргийн наадмыг амжилттай зохион байгууллаа.	100	100
5	71	Бүрдийн уянга зусланд амрагчдын эрхийн бичгийн үнийг шинэчлэн тогтоох тухай 2018,06,27	2	Амрагчдын үнийн тарифыг мөрдөн, орлогыг төрийн санд төвлөрүүлж, зуслангийн үйл ажиллагааг санхүүжүүлэхийг Гэр бүл хуухэд залуучуудын хөгжлийн газрын даргад үүрэг болгосугай.	Гэр бүл хуухэд залуучуудын хөгжлийн газрын дарга Ц.Ганзоригт үүрэг болгосугай	“Бүрдийн уянга” хүүхдийн зуслангийн зуны 4-н ээлжинд 481 сурагч, тусгай 1 ээлжинд 128 сурагч, гэр бүл, залуучуудын ээлжийн 9 удаагийн арга хэмжээнд 499, орон нутгийн удирдлагын чиглэл, хамтын үйл ажиллагааны хүрээнд 4 удаагийн арга хэмжээнд 343 үйлчлүүлэгчийг хүлээн авч, уг тогтоолоор баталсан амрагчдын үнийн тарифын дагуу үйлчилгээ үзүүлсэн. Дээрх үйлчилгээний хүрээнд нийт 65,688,250 төгрөгийн орлогыг төрийн санд төвлөрүүлж, холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд зарцууллаа.	100	100

6	72	Сонгон шалгаруулалтаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой талбайн тухай 2018.06.27	2	Сонгон шалгаруулалтаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжгүй талбайн мэдээллийг холбогдох газарт хүргүүлж, тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргад үүрэг болгосугай.	Аймгийн Засаг дарга О.Бат-Эрдэнэ	Уг тогтоолоор батлагдсан сонгон шалгаруулалтаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжгүй нийт 356,3 мян.га талбай бүхий 123 газрын тухай мэдээллийг Ашигт малтмалын тухай хуулийн дагуу Ашигт малтмал газрын тосны газрын Кадастрын хэлтэст аймгийн ИТХ-ын даргын 2018 оны 03 сарын 15-ны өдрийн 1/30 албан тоотоор хүргүүлж, бүртгүүлсэн.	100	100
7	73	Журам батлах тухай 2018.06.27	2	Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох журмыг хэрэгжүүлж, биелэлтийг хагас, бүтэн жилээр аймгийн ИТХТ-ийн хуралдаанд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг даргад даалгасугай	Аймгийн Засаг дарга О.Бат-Эрдэнэ	2018 онд Аймгийн МХГ, Цагдаагийн газрын хамтарсан хяналт шалгалт болон “Хуулиа мөрдье-21” аяны хүрээнд Архи, согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдаалах тусгай зөвшөөрөлтэй хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэлийн 95 газрын үйл ажиллагаанд цагдаагийн газартай хамтран хяналт шалгалт хийсэн. Хяналт шалгалтын явцад илэрсэн дутагдлыг арилгуулахаар 5 аж ахуйн нэгжид 17 заалт бүхий хугацаатай албан шаардлага өгч хэрэгжилтэнд хяналт тавин ажилласан. Согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн журмын төслийг шинэчлэн боловсруулж Аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн сайжруулах үүргийг авч дараагийн шатны хуралдаан болох Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулаад байна. 2018 оны онд тусгай зөвшөөрөл эзэмшигч 117 цэг болгож 6-аар цөөрүүлэн орон нутгийн орлогод 8,040,000 төгрөгийн орлогыг бүрдүүллээ.	100	100
8	75	Чиглэл өгөх тухай 2018.06.27	3	Баяр наадмын үйл ажиллагааны бэлтгэлийг сайтар ханган зохион байгуулахыг аймгийн Засаг даргад даалгасугай.	Аймгийн Засаг дарга О.Бат-Эрдэнэ	Ардын хувьсгалын 97 жил, аймаг байгуулагдсаны 77 жил, Сайнцагаан сум байгуулагдсаны 94 жилийн ойн баяр наадмыг нээлтийн арга хэмжээг зохион байгуулж, “Уухайн түрлэгтэй Монгол наадам” шинэ уран бүтээл туурвин, наадамчин түмэндээ өргөн барьсан. Дээрх уран бүтээлийг туурвихад Төв Халхын Дуулалт Жүжгийн театрын гэрээт ажилчдын цалингийн зардлаас нийт 21.5 сая, аймгийн баяр наадмын зардлаас 954.000 төгрөгийг соёл урлагийн арга хэмжээнд зарцуулсан.	100	100

9	93	Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай /Хүүхдэд ээлтэй дотуур байр/ 2018,10,04	2	Хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар ханган, шаардагдах хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөвт тусгах, хандив, тусламжид хамруулах замаар санхүүжүүлэх арга хэмжээг авч ажиллахыг аймгийн засаг даргад үүрэг болгосугай	Аймгийн Засаг дарга О.Бат-Эрдэнэ АИТХ-ын н/б-ийн дарга Ц.Мөнгөнцоож	Улсын төсөв болон бусад хандив тусламжаар Сайхан-Овоо суманд шинээр 100 хүүхдийн дотуур байр, Хулд суманд дотуур байрын их засвар, Өлзийт суманд дотуур байрын сантехник, гэрлийн монтаж солих, Дэрэн суманд дотуур байрны гал тогооны тоног төхөөрөмж, Эрдэнэдалай суманд дотуур байрны камержуулалт суурилуулсан зэрэг томоохон ажлууд хийгдэж, нийт 299 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. Хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 76.2%-тай байна. Дотуур байрны гадна талбайн чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулах зорилгоор 55 сая төгрөгийн төсөл боловсруулан, ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтад оруулсан.	70	70
10	96	Говь-Угтаал сумын нийтийн номын санг нэрэмжит болгох тухай /Барнангийн Доржпаламын/ 2018,10,04	2	Б.Доржпаламын бүтээл туурвилыг судлан залгамж хойч үедээ түгээн дэлгэрүүлж, гавъяат үйлсийг олон нийтэд сурталчлан алдаршуулахад идэвх санаачлагатай ажиллахыг тус сумын Засаг даргын орлогч, Нийтийн номын сангийн эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай	Говь-Угтаал сумын Засаг даргын орлогч Мөнх-Амгалан, Нийтийн номын сангийн эрхлэгч Х.Энхтуяа	Дундговь аймгийн утга зохиолын нэгдлийн 70 жилийн ойн хүрээнд Аймгийн ИТХТ-ийн 2018 оны 10 сарын 04-ний өдрийн 96 тоот тогтоолоор Говь-Угтаал сумын нийтийн номын санг нутгийн нэрт яруу найрагч Болор цомын эзэн Б.Доржпаламын нэрэмжит болгосон. 09 сарын 19-нд Засаг даргын тамгын газар, аймгийн төв номын сантай хамтран Болор цомын эзэн нэр яруу найрагч Б.Доржпаламыг алдаршуулах номын баярыг тэмдэглэн өнгөөр ажлын хүрээн шинэ номын үзэсгэлэн, Нэрт яруу найрагч Болор цомын эзэн Б.Доржпаламын үзэсгэлэн гаргалаа. Аяны удирдамжийн хүрээнд: Сурагчдын дунд яруу найргийн тэмцээн зохион байгуулснаас: 7-р ангийн сурагч Б.Баянцэнгэл 9-р ангийн сурагч Баяржавхлан, 5-р ангийн сурагч Эрдэнэсүвд нар тус тус шагналт байр эзэллээ. Баг байгууллагуудын дунд “Үлгэрийн баатрууд эргэж ирсэн нь” дүр бүтээх тэмцээн мөн Болор цомын эзэн Б.Доржпаламын хэн Яг түүн шиг дуурайж чадах вэ уралдааныг зохион байгуулснаас :Үлгэрийн баатрууд эргэж ирсэн нь дүр бүтээх тэмцээнд нийт 4 байгууллага оролцсоноос Хүүхдийн цэцэрлэгийн хамт олон Тэргүүн байр, Ерөнхий боловсролын сургуулийн хамт олон Дэд байранд шалгарлаа. Яг түүн шиг тэмцээний төрөл Засаг даргын тамгын газрын Ө.Мөнх-Амгалан Яг түүн шиг байж чадаж Тэргүүн байрын эзэн боллоо.	100	100

Төлөөлөгчдийн хурлын тогтоол

1	01	Дундговь аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх хөтөлбөр /2018-2028 он нэгдүгээр үе шат/ батлах тухай 2018,06,15	2	Нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх хөтөлбөрт тусгагдсан томоохон төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөв, жил бүрийн аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлэх, үр дүнг аймгийн ИТХ-д жил бүр тайлагнан ажиллахыг аймгийн Засаг даргад даалгасугай.	Аймгийн Засаг дарга О.Бат-Эрдэнэ	Жил жилд нь хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гаргахаар ажиллаж байна. 2019 оны УТХО-аар хийгдэх ажлын саналыг яамд руу хүргүүлсэн. 2019 онд УТХО-аар хийгдэх жагсаалтанд ТХДЖТ-ын барилга 2,000,000,000 төгрөг батлагдсан байна. Үндсэн чиглэлд 3 заалт тусгагдсан: 1. Эвент арга хэмжээ-20 сая 2. 3000 уртын дууч, морин хуурчдын наадам зохион байгуулах-30 сая 3. Төв Халхын Дуулалт Жүжгийн театрын барилга-2 тэр бум	100	70
2	03	Говь-угтаал суманд сумын төвийн баг байгуулах тухай 2018,06,15	2	Шинээр баг байгуулахтай холбогдуулан багийн урсгал зардлыг 2019 оны төсвийн төсөвт суулган батлуулахыг аймгийн Засаг даргад даалгасугай	Аймгийн Засаг дарга О.Бат-Эрдэнэ	Сумын төвийн багтай болох тухай иргэдээс санал гарч сумын иргэдээс санал авахад санал асуулганд оролцогчдын 87% нь сумын төвийн багтай болох саналыг дэмжсэн тул сумын ИТХ-ын хуралдаанд танилцуулж ИТХ-ын 2018 оны 5 сарын 28- ны өдрийн 33 тоот тогтоолоор сумын багийн төвтэй болох саналыг уламжлах тухай шийдвэр гарч иргэдийн дунд хэлэлцүүлэг хийж холбогдох материалыг бүрдүүлэн Аймгийн ИТХ-д оруулж аймгийн ИТХ-ын 2018 оны 6 сарын 15-ны өдрийн 03 тоот тогтоолоор сумын төвийн баг байгуулах шийдвэр гарсан. 2019 оны төсөвт 10,464,100 төгрөгний санал хүргүүлсэн. 12 сарын 4-ний өдрийн ИТХ-ын Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлнэ.	70	70

3	04	Орон нутгийн тусгай хэрэгцээнд газар авах тухай /Говь-Угтаал 10га/ 2018,06,15	2	Тусгай хэрэгцээнд авсан газруудыг зориулалтын дагуу ашиглуулахыг аймгийн Засаг дарга, Говь-Угтаал сумын Засаг даргад үүрэг болгосугай	Аймгийн Засаг дарга О.Бат-Эрдэнэ Говьугтаал сумын Засаг дарга Б.Доржсүмбэр	Орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан тогтоолыг Ашигт малтмал газрын тосны газарт 2018 оны 6 сарын 19-ний өдөр хүргүүлж, АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2018 оны 7 сарын 19-ний өдрийн 7/5030 тоот албан бичгээр “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын 4.1 дэх хэсгийн шаардлага хангаагүй үндэслэлээр бичил уурхай эрхлэх боломжгүй тухай дүгнэлт гарсан. Энэ тухай сумын удирдлагад нь мэдэгдсэн.	100	100
4	05	Орон нутгийн тусгай хэрэгцээнд газар авах тухай /Гурвансайхан - 4,94 га/ 2018,06,15	2	Тусгай хэрэгцээнд авсан газруудыг зориулалтын дагуу ашиглуулахыг аймгийн Засаг дарга, Гурвансайхан сумын Засаг даргад үүрэг болгосугай	Аймгийн Засаг дарга О.Бат-Эрдэнэ Гурвансайхан сумын Засаг дарга Л.Өлзийбат	Орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан тогтоолыг Ашигт малтмал газрын тосны газарт хүргүүлж, АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2018 оны 09 сарын 17-ны өдрийн 7/6330 тоот дүгнэлтийг хүлээн авч, сумын удирдлагуудад бичил уурхайчдыг зохион байгуулалтад оруулж, журмын дагуу үйл ажиллагаа явуулах чиглэл өгч ажиллаж байна.	100	100
5	06	Орон нутгийн тусгай хэрэгцээнд газар авах тухай /Өлзийт- 9,9га/ 2018,06,15	2	Тусгай хэрэгцээнд авсан газруудыг зориулалтын дагуу ашиглуулахыг аймгийн Засаг дарга, Өлзийт сумын Засаг даргад үүрэг болгосугай	Аймгийн Засаг дарга О.Бат-Эрдэнэ Өлзийт сумын Засаг дарга А.Эрдэнэбат	Орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан тогтоолыг Ашигт малтмал газрын тосны газарт 2018 оны 06 сарын 19-ний өдөр хүргүүлж, АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2018 оны 07 сарын 19-ний өдрийн 7/5030 тоот албан бичгээр “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын 4.1 дэх хэсгийн шаардлага хангаагүй үндэслэлээр бичил уурхай эрхлэх боломжгүй тухай дүгнэлт гарсан. Энэ тухай сумын удирдлагад нь мэдэгдсэн.	100	100

6	07	Орон нутгийн тусгай хэрэгцээнд газар авах тухай /Баянжаргалан 24,24 га/ 2018,06,15	2	Тусгай хэрэгцээнд авсан газруудыг зориулалтын дагуу ашиглуулахыг аймгийн Засаг дарга, Баянжаргалан сумын Засаг даргад үүрэг болгосугай	Аймгийн Засаг дарга О.Бат-Эрдэнэ Баянжаргалан сумын Засаг дарга Г.Туяа	Орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан тогтоолыг Ашигт малтмал газрын тосны газарт 2018 оны 06 сарын 19-ний өдөр хүргүүлж, АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2018 оны 07 сарын 19-ний өдрийн 7/5030 тоот албан бичгээр бичил уурхай эрхэлж болох тухай дүгнэлтийг хүлээн авч, сумын удирдлагуудад бичил уурхайчдыг зохион байгуулалтад оруулж, журмын дагуу үйл ажиллагаа явуулах чиглэл өгөн ажиллаж байна. Бичил уурхай эрхлэх дүгнэлт гаргасан 5 талбай дээр 9 нөхөрлөлийн 82 бичил уурхай эрхлэгч үйл ажиллагаа явуулахаар бүртгүүлэн гэрээ байгуулаад байна. Тус сумын бичил уурхай эрхлэгчдээс жонш худалдан авах аж ахуйн нэгж сонгон шалгаруулах ажлыг 10 сарын 16-ны өдөр зохион байгуулж, 3 аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж, гурвалсан гэрээ байгуулж ажиллах тухай мэдэгдэл өгч ажиллалаа.	100	100
7	09	Орон нутгийн тусгай хэрэгцээнд газар авах тухай /Дэлгэрхангай – 13,2 га/ 2018,06,15	2	Тусгай хэрэгцээнд авсан газруудыг зориулалтын дагуу ашиглуулахыг аймгийн Засаг дарга, Дэлгэрхангай сумын Засаг даргад үүрэг болгосугай	Аймгийн Засаг дарга О.Бат-Эрдэнэ Дэлгэрхангай сумын Засаг дарга О.Батчулуун	Орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан тогтоолыг Ашигт малтмал газрын тосны газарт 2018 оны 06 сарын 19-ний өдөр хүргүүлж, АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2018 оны 7 сарын 19-ний өдрийн 7/5030 тоот албан бичгээр бичил уурхай эрхэлж болох тухай дүгнэлтийг хүлээн авч, сумын удирдлагуудад бичил уурхайчдыг зохион байгуулалтад оруулж, журмын дагуу үйл ажиллагаа явуулах чиглэл өгөн ажиллаж байна. Одоогоор сумаас бичил уурхайчдаа зохион байгуулалтад оруулан гэрээ байгуулж эхлээгүй байна.	100	30
100 хувь- 11 , 70 хувь -5, 30 хувь- 1, хэрэгжилтийн дундаж хувь - 87.0								

ХЯНАСАН:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Ц.ЭРДЭНЭСҮРЭН

ТАЙЛАН ГАРГАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА М.ЦОГЗОЛМАА

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Э.ОДОНЧИМЭГ